

МОНГОЛ ДАХЬ АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Илтгэл бичсэн шинжээч **Д.ЛАМЖАВ**
2003.10.31

1. Ашгийн бус байгууллагын Үндсэн хууль дахь эх сурвалж

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд тунхагласан *иргэний нийгмийг хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгох* тухай үзэл санаа болон 16.10 дахь *нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийг иргэд баталгаатай эдэлнэ* гэсэн заалт хоёр нь төрийн биш байгууллагуудыг, түүний дотор ашгийн бус байгууллагуудыг үүсгэн байгуулж, тэдгээрт үйл ажиллагаа явуулж болохыг баталгаажуулсан Үндсэн хууль дахь эх сурвалж нь юм.

2. Ашгийн бус байгууллагад холбогдох Иргэний хуулийн заалтууд

2.1 Иргэний хуулийн 25-38 дугаар зүйлд ашгийн бус байгууллагад шууд холбогдох заалтуудыг тусгасан байна. 25.2-т ашгийн болон ашгийн бус хуулийн этгээдийг тодорхойлжээ: *Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.* Энд ногдол ашиг хуваарилахтай холбогдсон үндсэн шалгуур нь орхигдсон учраас тодорхойлолт болж чадсангүй.

2.2 Иргэний хуулийн 33.1-д *Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компаний хэлбэрээр байгуулна*, 33.2-т *ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршоо хэлбэрээр байгуулна* гэсэн хоёр заалтын сүүлчийн хэсэгт заасан хэлбэрүүдтэй шууд холбоотой заалт албан татварын тухай хуулиудад байхгүй байгаа нь эдгээр хэлбэр тогтоосны, тус бүрд тодорхойлсны ач холбогдолд эргэлзэх бодол төрүүлж байна. Дашрамд дурдахад, 25.2-т “төрөл”-ийг, 33-р зүйлд “хэлбэр”-ийг тодорхойлсон атлаа, сүүлчийн зүйлд “Хуулийн этгээдийн төрөл” гэсэн нэр өгсөн нь хайнга ажиллагаатай холбоотой боловч. Цаашилбал, Хоршооны тухай хуулийн 8.2.1-д *гишүүний нийлүүлсэн эд хөрөнгийг үнийн дүнгээр болон биет байдлаар давхар бүртгэнэ*, 14.1.6-д *Хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хүртээх эрхтэй* гэжээ.

Эндээс хоршоо нь ногдол ашиг хуваарилахгүй гэсэн дүгнэлтийг, улмаар ашгийн бус байгууллага мөн гэж үзэх хууль зүйн үндэслэл харагдахгүй байна. Энэхүү хоёрдмол, шуудхан хэлэхэд шударга бус зохицуулалт нь, ялангуяа хөдөөг хоршоогоор торлон тэндэхийн хувийн жижиг өмчтөнүүдийг энэ заалтын дагуу хөлжсөн цөөн тооны этгээдээс хараат болгох улс төрийн үр дагаварт хүргэж магадгүй.

2.3 Иргэний хуулийн 36.6-д *Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд орохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө* гэжээ. Энэхүү эгзэгтэй заалтаас санаа аван намуудыг хэрхэн зохицуулсныг сонирхож үзэв. Үндсэн хуулиас иш татсан дээрх заалт болон Улс төрийн намуудын тухай хуулийн 46, 11а заалтын дагуу нам нь гишүүнчлэлтэй ашгийн бус байгууллага байх ёстой. Гэвч энэ талаар Иргэний хуульд ч, Улс төрийн намуудын тухай хуульд ч ил заалт үгүй байна. Намаас бусад хуулийн этгээд нь түүнийг улсын бүртгэлд бүртгэсэн буюу тусгай зөвшөөрөл олгосон төрийн байгууллагад тайлагнадаг байхад, намыг Дээд шүүх бүртгэдэг боловч Намуудын тухай хуулийн 10-р зүйлд *Нам нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана. Нам санхүүгийнхээ тайланг жил бүр Монгол Улсын Засгийн газарт тавина* гэжээ. Энэ нь намуудыг ямар нэг байдлаар хуулийн гадна тавилаа гэсэн шүүмжлэлд өртөх үндэслэлийг бий болгож байна. Учир нь төрийн эрх барьж буй нам санхүүгийн хяналтын гадна орших боломжийг хуулиар зөвшөөрч байна.

2.4 Иргэний хуулийн 143.1-д *Нийтийн зориулалттай орон сууцны нэг байшинд хоёр буюу түүнээс дээш өрх сууц өмчлөгч болсон тохиолдолд дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоо (цаашид “холбоо” гэх)-г байгуулна гэж, 143.2-т зэрэгцэн орших хэд хэдэн орон сууцны барилгад сууц өмчлөгчид нэгдэн нэг холбоо байгуулж болно гэж, 143.3-т Сууц өмчлөгчдийн холбоо хуулийн этгээдийн эрхгүй байна гэж, 143.4-т *Орон сууцанд оршин суугаа сууц өмчлөгч бусад этгээд заавал тухайн холбооны гишүүн байна гэж, 143.5-д Орон сууцны бүрэлдэхүүнд төрийн болон орон нутгийн өмчийн сууц байгаа бол өмчлөгчийн эрх бүхий байгууллагаас томилсон төлөөлөгч холбооны гишүүн байна гэж, 148.1.3-т Дундын өмчлөлийн зүйлийг ашиглах, захиран зарцуулахад өөрт оногдох хэсгээр саналын эрхтэй байна* гэжээ.*

Сууц өмчлөгчдийн холбоог ашгийн буюу ашгийн бус аль нь болохыг тухайн холбоо өөрөө тодорхойлох, улмаар түүнээс нь хамааран саналын эрх тодорхойлогдох ёстой боловuu. Орон сууцыг эзэмшигч нарт нь үнэгүй хувьчилсан тул одоогийн СӨХ-үүд нь бараг бүгдээрээ ашгийн бус байгууллагын шинжтэй байна. СӨХ хуулийн этгээдийн эрхгүй гэсэн заалтыг Үндсэн хуулийн 16.10 заалтад нийцэж байна гэж дүгнэх үндэслэлийг олоход бэрх байх бизээ. Энэ заалт орж ирэх болсон сэдэлт нь нэг талаас бизнесийн зорилгоор аль болох ашигтай байрлалд газрын зөвшөөрөл авах, нөгөө талаас оршин суугчид хүүхдийн тоглоомын талбайг хамгаалахаас эхлэн цонхны гэрлээ хаалгахгүйн төлөө олон удаа гарсан зөрчлийг намжаахад чиглэгдсэн байна. Иргэний нийгмийн зарчмаас ухаралт хийх замаар зөрчлийг шийдэх гэж оролдсонд л асуудлын зангилгаа нь байгаа юм.

3. Тусгай хуулиар зохицуулагдсан байгууллагууд

3.1 Тусгай хуулиар зохицуулагдсан аливаа төрийн биш байгууллага Иргэний хуульд заасан ашгийн, ашгийн бус хоёр төрлийн зөвхөн нэгэнд нь хамаарагдах хуультай. Гэтэл аль төрөлд хамаарахыг нь хуулиар тодорхойлох боломжгүй байгууллагууд байна. Энэ нь дараах байдлаар илэрч байна: 1) аль төрөлд хамаарах талаар хуулийн шууд заалт байхгүйгээс гадна 2) аль төрөлд хамаарахаа байгууллага өөрөө сонгох ёстой гэсэн хуулийн заалт байдаггүй. Хоёр төрлийн альныг нь ч сонгосон, сонголтоосоо хамааран нэг хэсэг зүйлийг олохын зэрэгцээ бас нэг хэсэг зүйлийг алддаг. Аль ч хэсгийг нь алдахыг тэвчиж чаддаггүй хувийн сонирхолтой байгууллага, хувь хүмүүс байдаг нь амьдралын үнэн юм. Хуулийн ийм тодорхой бус байдал нь ногдол ашиг хуваарилахын зэрэгцээ албан татвараас чөлөөлөгдөх буюу хөнгөлөлт эдлэх давуу байдлыг эдгээр байгууллага, хүмүүст олгох эрсдэлтэй байна.

3.2 Үүнийг зарим байгууллагын жишээн дээр хүснэгтээр харуулъя:

Байгууллагууд ба тэдгээрт зориулсан тусгай хууль, Хуулийн кодын жагсаалт дахь File	Хуульд шууд зааснаар			Тодорхой бус байдал: өмнөх гурван тохиолдлын аль нь ч биш
	Ашгийн бус байгууллага	Ашгийн төлөө байгууллага	өмнөх хоёрын нэгийг байгууллага өөрөө сонгох ёстой	
Намууд: Улс төрийн намуудын тухай, 90-h-03	-	-	-	+
Үйлдвэрч/ эвлэлүүд: Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, 91-h-05	-	-	-	+
Сүм хийд: Төр, сүм хийдийн харилцааны тухай, 93-h-21	-	-	-	+
Боловсролын: Боловсролын тухай, 02-h-13	+	-	-	-
Эрүүл мэндийн: Эрүүл мэндийн тухай, 98-h-16	-	-	-	+
Улаан загалмайн: Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай, 00-h-14	+	-	-	-
Нотариатын: Нотариатын тухай, 97-h-10	-	-	-	+
Өмгөөлөгчдийн холбоо: Өмгөөллийн тухай, 02-h-18	-	-	-	+
Хоршоо: Хоршооны тухай, 98-h-10	+	+	-	-
Худ.аж үйлд.танхим: Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай, 95-h-31	+	-	-	-
Соёлын: Соёлын тухай, 96-h-04	-	-	+	-
Сууц өмчлөгчдийн холбоо: Иргэний хууль, 02-h-08, Хууль гарна	-	-	-	+

4. Ашгийн бус байгууллага ба албан татвар

4.1 Иргэний хуулийн 26.6-д *Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулна* гэж, 26.7-д *Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй* гэж зааснаас ашгийн бус байгууллага дүрмийн зорилгодоо нийцээгүй үйл ажиллагаа явуулж болохгүй бололтой. Цаашилбал, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 8.1.1-д *дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан үндэслэлээр ТББ-ыг шүүх албадан татан буулгана* гэж ч заасан байна.

4.2 1997.1.31-нд Татварын ерөнхий хуульд 2.3 *Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна* гэсэн заалтыг нэмсэн байна. Энэ заалтыг хэрэгжүүлэх ажиллагаа бусад хуульд байсан холбогдох заалтуудыг эхэлж хүчингүй болгохын өмнө өгсөн амлалт)- хоёрдох шаттайгаар хийгдсэн байна. Хоёрдох шатанд амлалт биелэгдээгүй явдал гарчээ. Тухайлбал, ТББ-ын тухай хуулийн анхны бичвэрийн 22-р зүйлд байсан дараах заалт сураггүй алга болжээ: Хандивлагчийн албан татвар ногдох жилийн орлогоос нийгэмд үйлчилдэг ТББ-д өргөсөн хандивын нийт дүнгээр тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцоолон хасч татварын хөнгөлөлт үзүүлнэ. Нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй ТББ-д эд хөрөнгө өвлүүлсэн бол өвлүүлэгчийг өв залгамжлалын албан татвараас чөлөөлнө.

4.3 **Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хууль.** Хуулийн 3.1.1-8, 3.2 заалтаар аж ахуйн нэгж, хоршоо, төрийн бус байгууллага, шашны байгууллагаас гадна аливаа аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд татвар төлөгч байгууллага юм. Энэ хуулинд нам, үйлдвэрчний байгууллага, ашгийн бус байгууллагатай холбогдсон ил заалт байхгүй байна.

4.4 Энэ хуулийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох тухай 5.1.1 заалтад (үргэлжилсэн үгийн зохиолын хэлбэрээр бичигдсэн) *хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны эрсдлийн санд; бусад үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны болзошгүй алдагдлыг нөөц санд; зээлийн болон бусад үйл ажиллагаа зэрэг эрхэлдэг хоршооны тухайд аль нэг санд нь төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцно* гэжээ.

Мөнхүү заалтыг маш анхааралтай, тэвчээр гарган уншвал түүн дотор *бусад өгсөн хандивыг албан татвар ногдуулах орлогоос хасахгүй* гэснийг олж үзэж болохоор байна. Хууль дотор тухайн хуулийн өсөж өндийсөн болон бууран доройтсон түүхийг бичдэг, ингэхдээ уншигчийг төөрөгдүүлэх байдлаар бичдэг өвөрмөгц жишиг Монголд тогтоод байгаа билээ. Тэнд бичснээр, налуугаар ялгасан эдгээр заалт нь 2001.11.9 болон 2003.4.24 хуулиар нэмэгдсэн юм байна. Энэ жишгийн нэг сул тал нь гэвэл, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр түүх нь зузаараад ирэхийн цагт, хуулийн үйлчилж байгаа заалтыг олоход хэрэглэгч нарт бэрхтэй бөгөөд тааламжгүй болно.

4.5 Энэ хуулийн 7.1.2-т *ТББ-ын гишүүд, дэмжигчдийн татвар хандивыг, 7.1.7-д нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй ТББ-ын орлогыг орлогын албан татвараас чөлөөлнө* гэж заажээ. 13, 14, 15 дугаар зүйл зэрэг нийт аж ахуйн нэгж, байгууллагад албан татварын хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон заалтыг энд дурдсангүй.

4.6 ТББ-ын тухай хуулийн 8.1-д *Дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, эсвэл хууль тогтоомж ноцтой буюу удаа дараа зөрчсөн үндэслэлээр ТББ-ыг шүүх албадан татан буулгахаар* заажээ. Иймээс Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн дээр иш татсан 3.1.4 болон 7.1.7 заалтаас нийгэмд үйлчилдэг ТББ бол албан татвар төлөгч биш, гишүүддээ үйлчилдэг нь бол -мөн гэж үзэх үндэслэл байгаа юм. ТББ-ын хуулийн төслийг гадаадын шинжээчтэй хамтран боловсруулж байх үед “хэрэв ТББ дүрмийнхээ зорилгод нийцээгүй аж ахуйн үйл ажиллагаа явуулбал түүнээс олсон орлогод нь бусдын адил албан татвар ногдуулна” иймээс татварын албанд бас тайлан гаргах нь зүйтэй гэсэн заалтууд байсан. Хууль төрөх үеийн олон гар дамжсан ажиллагааны үед тэр үйл ажиллагаа хориглогдсон боловч тайлан тэнцэл гаргах нь хэвээр хоцорсон байна. Тэр үед дүрмийн зорилгод нийцээгүй үйл ажиллагаа нь давамгайлаад ирвэл статусаа өөрчилдөг уян хатан механизмийг санал болгож байснаас биш шүүхээр албадан татан буулгахын нэгэн үндэслэл болгож байгаагүй билээ.

4.7 Татварын ерөнхий хуулийн 6.1-д *Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага татварын албанд бүртгүүлнэ*, 6.2-т *Татвар төлөгч иргэнийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно* гэж, цаашилбал 10.6-д *Аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс*

шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож тогтоосон хугацаанд төсөвт төлөх үүрэг хүлээнэ гэж, 24.2.5-д аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч төсөвт төлөөгүй бол түүнийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөс нөхөн төлүүлэх бүрэн эрхийг татварын улсын байцаагч хэрэгжүүлнэ гэжээ. Эдгээр заалтыг Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай хуулийн 8.4, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн заалтуудаар үүрэг болгон лавшруулан тодруулжээ.

Үндсэн хуулийн 17.1.3-д Хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь Монгол Улсын иргэний ёсчлон биелүүлэх үндсэн үүрэгт хамаарна гэж заажээ. Иймээс иргэдийн албан татвар төлөх үүргийг аж ахуйн нэгж болон ТББ-д хүлээлгэх, улмаар хариуцлага тооцох –хатуу зохицуулалт нь Үндсэн хуулийн иш татсан заалтыг зөрчсөн байж тун болзошгүй. Төр өөрийн харьяаны байгууллагад, эсвэл харилцан хүлээн зөвшөөрсөн гэрээний үндсэн дээр иргэдийн байгууллагад ийм үүрэг, хариуцлага оноож байгаа бол өөр хэрэг. Үндсэн хууль бол иргэдээс ирээдүйн төртэйгөө байгуулсан, иргэдийн хувьд давуу эрхтэй гэрээ юм шүү гэдэг талаас нь асуудалд хандах нь зүйтэй боловуу.

5. Ашгийн бус байгууллагыг байгуулах эрх

5.1 ТББ-ын тухай хуулийн 4.1, 3.1 заалтаар ТББ-ыг тодорхойлсон байна. Шалгуур шинж нь:

- Ашгийн бус байгууллага (ө.х, ногдол ашиг хуваарилдаггүй) байх,
- Нам, сүм хийд, үйлдвэрчний эвлэлийн байгууллага биш байх,
- Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс иргэд буюу төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс сайн дурын үндсэн дээр байгуулагдах бөгөөд
- Төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг байх.

5.2 Энэ хуулийн 5.1-д Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран ТББ байгуулах эрхтэй гээд, 5.6-д энэхүү эрхийг монголын харьяалалгүй иргэдэд ч нэгэн адил хамаарахаар заасан байна. 6 дугаар зүйлд зааснаар, Үүсгэн байгуулагчдаас ТББ байгуулах шийдвэр гаргаж дүрмээ баталснаар ТББ-ыг үүсгэн байгуулагдсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

5.2 Иргэний хуулийн 30.1-д Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно гэсэн, 30.2-т Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно гэсэн нь хуулийн этгээдийн эрхтэй, ашгийн төлөө болон ашгийн бус байгууллага үүсгэн байгуулахад нэгэн адил хамаарах заалтууд юм. Иргэний хууль Иргэдийн байгууллагуудаас хуулийн этгээдийн эрх авахгүйгээр оршин тогтнох эрхийг зөвхөн СӨХ-д, гэхдээ тулгалтаар, олгосон байдал харагдаж байна.

6. Ашгийн бус байгууллагыг бүртгэх

6.1 ТББ-ын тухай хуулийн 15-18 дугаар зүйлд ТББ-ыг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасахтай холбогдсон заалтууд тусгагдсан байна. Ялангуяа 16 дугаар зүйлд байгаа бүртгэх журам нь ТББ-ын хуулийн этгээдийн эрх олж авах эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалт юм. ТББ-ыг Хууль зүйн яам бүртгэх бөгөөд ТББ-аас Яаманд гаргаж өгөх баримт бичгийг тодорхой зааж өгчээ:

- Өргөдөл (удирдах зөвлөлийн даргын улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн), өргөдөлд бусад холбогдох баримт бичгийг хаясаргана. Үүнд:
- ТББ-ын нэр хаяг,
- Удирдах зөвлөлийн гишүүд, дарга, гүйцэтгэх захирлын нэр, хаяг,
- Удирдах зөвлөлийн даргын гарын үсгээр баталгаажсан ТББ-ын дүрэм,
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай баримт.

6.2 ТББ бүртгүүлэх өргөдөлөө Яаманд шууд, эсвэл нутгийн захиргааны байгууллагаар уламжлуулан Яаманд хүргэж болно. Өргөдлийг анх хүлээн авсан төрийн байгууллага нь дараах шалтгаанаар өргөдлийг ТББ-д буцааж болно:

- Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, эсвэл
- ТББ-ын хуулийн 10 дугаар зүйлд заасан дүрэмд тавих шаардлагыг хангаагүй.

6.2 Өргөдөл, бусад холбогдох баримт бичгийг анх хүлээн авсан төрийн байгууллага нь энэ тухай огноог ТББ-д албан ёсоор мэдэгдэнэ. Яам зохих шаардлагыг хангасан өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүртгэх, эсвэл дараах шалтгаанаар бүртгэхээс татгалзах шийдвэрийн нэгийг гаргана:

- ТББ-ын зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй, эсвэл
- ТББ-ын нэр нь өмнө бүртгүүлсэн ТББ-ын нэртэй давхардсан.

6.3 Яам ТББ-ыг бүртгэхээс татгалзсан бол үндэслэл бүхий албан ёсны хариу өгөх бөгөөд энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно. Хэрэв дээр заасан хугацаанд Яамнаас албан ёсоор хариу аваагүй бол хууль ёсоор бүртгүүлсэнд тооцогдож үйл ажиллагаагаа явуулах бөгөөд зохих журмын дагуу бүртгэлийн гэрчилгээг нөхөн авна.

6.4 Иргэний хуульд бүртгэлийн талаар заалт бараг байхгүй шахам бөгөөд “Хуулийн этгээдийн нэр” гэсэн гарчигтай 27 дугаар зүйл дотор 27.5 *Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ* гэсэн ганц заалт л байна. Ийм байдлаар хуульчилсан нь хуулийн этгээдийн эрх олж авах нь зөвхөн нэрийн төдий зүйл мэт ойлголт өгч болох юм.

6.5 Татан буугдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийг хэрхэх талаар Иргэний хуульд дэлгэрэнгүй заасан байна. Тэдгээрийн дотор 32.9-д *Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ* гэж, 32.10-д *Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчид шилжүүлнэ* гэж заасан байна.

Харин, ТББ-ын тухай хуулийн 7.2, 8.2, 25.3-т зааснаар татан буугдсан ТББ буюу сангийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна гэж заажээ.